



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 06 сарын 28 өдөр

Дугаар 77

Номгон

Г

Т

Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын  
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хуучин конторын барилгыг  
актлан данснаас хасаж, газрыг шилжүүлэх тухай

Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 1980 онд ашиглалтад орсон 2018 онд дахин үнэлж 162 785 055,00 төгрөгөөр бүртгэлд тусгасан хуучин конторын барилгын цахилгаан дамжуулагч монтаж галын аюулгүй байдлын шаардлага хангахгүй улмаас дээвэр шатаж цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй талаар Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагчийн 2019 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 02 дугаар бүхий дүгнэлт гарсан. Уг барилгын 636 м<sup>2</sup> талбай бүхий газрыг сумын Засаг даргын 2016 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/49 дүгээр захирамжаар ахуй үйлчилгээний зориулалтаар 15 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр газар эзэмших гэрчилгээг Засаг даргын Тамгын газар олгосон байна. Улсын төвийн хөрөнгөөр баригдах Соёлын төвийн шинэ барилгыг уг конторын барилгын газрыг чөлөөлж барилгын ажлыг яаралтай эхлүүлэх шаардлагатай байгаа ТЭМДЭГЛЭЭД:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын "а", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.9.2, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 40 дүгээр тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах журам"-ын 1.3, 5.1, 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 1980 онд ашиглалтад орсон 2018 онд дахин үнэлж 162 785 055,00 төгрөгөөр бүртгэлд тусгагдсан хуучин конторын барилгыг акталж данснаас хассугай.
2. Актлагдсан конторын барилгаас ашиглаж болох барилгын материалыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл, аймгийн Орон нутгийн өмчийн газрын хяналтан дор комисс томилон хүлээн авч, үнэлгээ, дүгнэлт гарган худалдан

борлуулж орлогыг сумын ерөнхий орлогын дансанд төвлөрүүлэхийг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга /Д.Готовдорж/-д зөвлөсүгэй.

3. Сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй конторын барилгын доорх газрыг сумын Соёлын төвд шилжүүлэхийг сумын Засаг дарга /З.Мөнхтөр/-д даалгасугай.

4. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Идэрмөнх/-д дор дурдсан ажлыг зохион байгуулахыг даалгасугай.

4.1. Актлагдсан барилга, шилжүүлэн авсан газрын хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

4.2. Энэ тогтоолын хэрэгжилтийг 2019 оны 07 дугаар сард багтаан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албанд ирүүлэх.

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

